



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/401

Чингис хот

Коронавируст (Ковид-19) халдварын
эмчилгээний үеийн бэлэн байдлыг хангах
ажлын хүрээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын эмчилгээний үеийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 10,030,452 (арван сая гучин мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосугай.

2. Дээрх зардалд шаардлагатай зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ

23111136